

**УВС АЙМГИЙН ТҮРГЭН СУМЫН НУТАГ ДЭВСГЭРТ “ХАР УСНЫ ЭХЭН” ХЭМЭЭХ  
ГАЗАР ДАХЬ “ДЭГЛИЙ ЦАГААН” НИСЭХ БУУДЛЫН 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧИН  
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

Аймаг: Увс

Сум: Түргэн

Байгуулгын нэр: “ДЭГЛИЙ ЦАГААН” нисэх буудал

Регистерийн дугаар: 2628546

Хянасан:

Увс аймгийн БОАЖЯ-ны хариуцсан мэргэжилтэн

/ А.Пүрэвсосор /

Боловсруулсан:

“ДЭГЛИЙ ЦАГААН” нисэх буудлын  
холбооны навигацийн техникч

/ С.Баасанжав /

2023 он

## **АГУУЛГА**

- 1.ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР
- 2.ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА
- 3.ТӨСЛИЙН ТАЛБАЙ, ТҮҮНИЙ ОРЧНЫ БАЙГАЛЬ ОРЧИН , НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ
- 4.ГАЗАР АШИГЛАЛТ
- 6.ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОДОРХОЙЛОЛТ
- 7.БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗОРИЛГО
- 8."ДЭГЛИЙ ЦАГААН НИСЭХ БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ХҮЧИН ЧАДАЛ
- 9.СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ
- 10.ОРЧНЫ ТОХИЖИЛТ, ЦЭЦЭРЛЭГЖҮҮЛЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ
- 11.ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ
- 12.ТҮҮХ СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ
- 13.ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ
- 14.ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ
- 15.ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛЫНТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ
- 16.ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БУСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ

## **ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР**

ААНБ- Аж ахуйн нэгж байгуулга

ХБХЗ-Хөөрч буух, хөөрөх хөөрөх зурvas

БОТБҮ-Байгаль орчны төлөв байдлын тайлан

БОНБЕҮ-Байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээ

БОННҮ-Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ

БОНХС-Байгаль орчны ногоон хөгжлийн сайд

БОМТ-Байгаль орчны менежментийн төлөвлөгөө

БОАЖС-Байгаль орчин аялал жуулчлалын сайд

ТХГН-Тусгай хамгаалалттай газар нутаг

ЗТБХБ-Зам, тээвэр барилга хот байгуулалт

ИНЕГ-Иргэний нисэхийн ерөнхий газар

ИНХ-Иргэдийн нийтийн хурал

ГХГЗГ-Газрын харилцаа геодези, зураг зүйн зураг

МУ-Монгол улс

УЦУОШГ-Ус цаг уур орчин шинжилгээний газар

## **БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗОРИЛГО**

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь төсөл хөрөгжих нутаг дэвсгэрийн байгаль орчиныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, нарийвчилсан үнэлгээний зөвлөмжийн хэрэгжилтийг хангах, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжиж буй орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаварыг хянах, илрүүлэх үндсэн зорилготой.

БОМТ-г хэрэгжүүлэхэд төсөл хэрэгжүүлэгч дараах бодлогыг баримтална.

- БОМТ нь төсөл хэрэгжүүлэгчийн үйл ажиллагаа, санхүүгийн боломж нөөцтэй уялдсан байх.
- БОМТ –ний хэрэгжилтийг төсөл хэрэгжүүлэгч өөрөө болон оршин суугчидын зүгээс хэрхэн хянаж, харилцан хамаарал бүхий бодит үр дүн хүрэх.
- БОМТ –г хэрэгжүүлснээр төсөл хэрэгжүүлэгчийг хөндлөнгийн хяналт, шалгалтад тэсвэртэй байх зэрэг болно

## **Дэглий Цагаан нисэх буудлын үйл ажиллагаа, хүчин чадал**

Тус нисэх буудлыг 1958 оны 04-р сарын 25-нд БНМАУ-ын сайд нарын зөвлөлийн 112 –р тогтоолоор иргэний зориулалтын нислэг үйлдэх чиглэлүүдийг тогтоож тогтмол нислэг үйлдэж эхэлсний нэг нь Увс аймгийн Дэглий Цагаан нисэх буудал байсан. Дэглий Цагаан нисэх буудлын барилгын цогцолбор, агаарын хөлөг хөөрч буух хатуу хучилттай зурvasыг 2011 оны 06-р сарын 25-аас ашиглаж эхэлсэн ба цагт 100 хүнд үйлчлэх хүчин чадалтай тус нисэх буудал нь Ховд, Баян-Өлгий аймгуудын бэлтгэл аэродромын үүрэг гүйцэтгэдэг.

Нисэх буудал нь нислэгийн аюулгүй байдал , аюулгүй ажиллагааг хангаж, авиа компаниудад найдвартай , зорчигчидод соёлтой шуурхай үйлчилхэд бүхий л үйл ажиллагаагаа чиглүүлнэ.

Нисэх буудал нь дараах үйлчилгээнүүдийг үзүүлдэг;

1. Нислэгийн удирдлага.
2. Холбоо навигаци.
3. Агаарын хөлгийн газрын техник үзлэг, удирдлага.
4. Агаарын хөлгийн шатахуун хадгалалт, лаборатори оншилгоо, сумалгаа.
5. Авран хамгаалах, гал унтраах.
6. Аюулгүй байдлын үзлэг.
7. Ачаа тээшийн үйлчилгээ.

Дэглий Цагаан нисэх буудал нь 3С ангилалд хамаарах 2-р зэрэглэлийн нисэх буудал бөгөөд одоогийн байдлаар нийт 34 ажиллагсадтай хэдий ч жишиг орон тоо нь 28 гэж тодорхойлсон байна.

Монгол улсын УИХ-ын 2013-оны 02-р сарын 07-ны өдрийн 18-р тогтоолоор баталсан төрөөс иргэний нисэхийн салбарт 2020 он хүртэл баримтлах бодлогын хүрээнд “Дэглий Цагаан” нисэх буудлыг цагт 300 зорчигчидод үйлчлэх хүчин чадалтай болгон өргөтгөх зорилготой инженерийн барилга байгууламжын зураг төслийг боловсруулах ажлыг гүйцэтгэж эхэлсэнээр тус нисэх буудал нь аэродромын хяналтаар 4с ангилалд шилжинэ.

## 1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛАГА

### 1.1 ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭГЖИЙН ТУХАЙ ТОВЧ МЭДЭЭЛЭЛ

Төслийн нэр:

“Дэглий цагаан” нисэх буудал

Төсөл хэрэгжүүлэгч:

ИНЕГ Төрийн өмчт Увс аймаг дахь салбар

Улсын бүртгэлийн дугаар 9013001003

ААН-ын регистрийн дугаар 2628546

Салбарын гэрчилгээний дугаар 000004809

Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг:

Увс аймаг Түргэн сум Баянхайрхан баг

Утас: 976-70452550

Майл хаяг: [uvs.airport@mcaa.gov.mn](mailto:uvs.airport@mcaa.gov.mn)

Сайт: <https://www.mcaa.gov.mn/>

Төсөл хэрэгжих газрын орон  
нутгийн харьяалал:

Увс аймгийн Түргэн сум, Баянхайрхан баг,

ИНЕГ Төрийн өмчт Увс аймаг дахь салбар нь хуулийн этгээдийн эрх эдлэхгүй, эрх бүхий байгууллагаас баталсан журмын дагуу үйл ажиллагаа явуулна. Эрх бүхий этгээд нь Иргэний Нисэхийн Ерөнхий Газар байна.




Зураг 1.2 “Дэглий цагаан” нисэх буудлын бүтэц, зохион байгуулалтын схем

Тус нисэх буудал нь баталсан орон тооны дагуу захиргаа аж ахуй, нислэг хөдөлгөөн аэронавигацийн хэсэг, аэродром ашиглалтын хэсэг, аюулгүй байдлын хэсэг, газрын тусгай үйлчилгээний хэсэг, голын бүлэг гэсэн бүтэц зохион байгуулалттайгаар ажиллаж нисэхийн аюулгүй байдал аюулгүй ажиллагаа, хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангаж, хэвийн үйл ажиллагааг алдагдуулахгүйгээр ажлын зохион байгуулалтыг хийж ажиллаж байна.

## 2. Төслийн талбай, түүний орчны байгаль орчин, нийгэм-эдийн засгийн төлөв байдлын товч тодорхойлолт

### 2.1 Төслийн байршил

“Дэглий цагаан” нисэх буудал нь Увс аймгийн Түргэн сумын 1-р багийн нутаг дэвсгэрт сумын төвийн зүүн хойд зүгт 18 км, Улаангом хотоос баруун зүгт 14 км зайд оршино.



Зураг 2.1 “Дэглий цагаан” нисэх буудлын байршлын зураг

“Дэглий цагаан” нисэх буудлын аэродромын байршлын газар зүйн үзүүлэлтүүд:

- Аэродромын лавлах цэг: N 50°04'00", E 91°56' 11"
- Аэродромын өндөршил: д.т.д 935 м
- Температурын заалт : 27.7°

#### 2.1.2. Газар олголт

“Дэглий цагаан” нисэх буудлын эзэмшлийн газар нь Увс аймгийн Улаангом болон Түргэн сумдын нутгийг дамнан байршсан ба газар эзэмших эрхийн дараах баримт бичгүүдийг БОНHY-ний тайланд нийлүүлсэн болно. Үүнд:

- Увс аймгийн газрын харилцаа, Барилга хот байгуулалтын газраас газар ашиглалт, зохион байгуулалтын хяналтын хуудсаар баталгаажуулсан 8520000647 нэгж


талбарын дугаартай газрыг эзэмшлийн эрхээр Түргэн сумын 1 дүгээр багийн нутаг, кадастрын мужийн 200 дахь нэгжид олгосон

- Увс аймгийн Түргэн сумын Засаг даргын 2018 оны 09 дугаар сарын 28-ний өдрийн А/106 тоот шийдвэрээр ИНЕГ ТӨААҮГ-ийн Увс аймаг дахь салбар нь нисэх зурvasын зориулалтаар  $13186906\text{m}^2$  талбайг 15 жилээр эзэмших эрхийг баталгаажуулж 439773 тоот гэрчилгээ олсон байна.

### 2.1.3. Газар ашиглалт

Нисэх буудлын зориулалтаар эзэмшиж байгаа нийт 131.8 га газрыг дараах байдлаар ашиглаж байна. Үүнд:

- |  |                     |
|--|---------------------|
| • Аэродромын үйлчилгээний барилга байгууламж | 1798 $\text{m}^2$   |
| • Хатуу хүчилт хийсэн талбай                 | 125000 $\text{m}^2$ |
| • Ногоон байгууламж байгуулсан               | 660 $\text{m}^2$    |
| • Шатахууны агуулах                          | 1960 $\text{m}^2$   |



## **ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОДОРХОЙЛОЛТ**

Увс аймгийн Дэглий Цагаан нисэх буудал төсөлд байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээг 2011 онд байгаль орчны зөвлөх үйлчилгээний Мегас Консалтант ХХК хийж БОНБНҮ-ний тайлан боловсруулсан байна.

Төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд нөлөөлөх байдлыг байгаль орчны бүрдэл хэсэг тус бүрээр үнэлснээс гадна төслийн болзошгүй болон гол сөрөг нөлөөллүүдийг тодорхойлжээ.

Төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг тодорхойлоходоо байгаль орчны бүрдэл хэсэг бүрийн тухайн үеийн төлөв байдлыг тодорхойлон үнэлгээний суурь үзүүлэлт болгон авч нөлөөллийг эрчмийн аргаар үнэлсэн байна.

Мөн байгаль орчны бүрдэл хэсэг бүрт төслөөс үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах зөвлөмжийг өгчээ.

Нисэх буудлын талбайд хамгийн ойр байршилтай түүх соёлын дурсгалт газар байхгүй болохыг тэмдэглсэн байна.

Дэглий Цагаан нисэх буудлын агаар бохирдуулах эх үүсвэрүүдийн үйл ажиллагаа нь улирлын чанартай эсвэл байнгын бус буюу зөвхөн онгоц хөөрч, буух зуур богино хугацаанд ажиглагдаж байна.

Манай улсын аливаа төслийн үйл ажиллагаанаас орчны агаарын чанарт үзүүлэх нөлөөллийн хамрах хүрээг тогтоо шалгуур үзүүлэлтийг тодорхойлсон баримт бичиг стандарт байхгүй байна.

### **Дуу шуугианы нөлөөлөл;**

Агаарын хөлөг хөөрч буух , явгалах үеийн хөдөлгөөн хөдөлгүүрийн ажиллагаанаас дуу шуугиан богино хугацаанд үүснэ. Төслийн талбай орчимд үүсэх эдгээр дуу чимээ дан дангаараа орчны шуугианыг үүсгэдэггүй ба янз бүрийн эх үүсвэрээс үүдэлтэй дуу чимээнүүдийн нэмэгдэлт, ойлт, хугаралтын үр дүнд газрын гадарга орчимд шуугиан үүсдэг. Мөн өдөр тутмын үйл ажилгаанд ашиглагдах машин тоног төхөөрөмжийн дуу чимээ орчны шуугианы төвшнийг нэмэгдүүлнэ.

### **Гадаргын усанд үзүүлэх нөлөө ;**

Төслийн талбай орчим нь Увс аймгийн Түргэн суманд байрлах ба гадаргын усны сүлжээ нь Төв азийн гадагш урсгалгүй ай сав Хархираа-Түргэн голын сав газарт багтдаг .Нисэх буудлын аэродромыг 2 сайрыг хөндлөн гарна.

Гадаргын усны хамгийн их урсац нь хур борооны улирал буюу 6-8 сард зарим жилүүдэд хаврын шар усны үерийн үед ажиглагддаг ба Цалгар гол хойд өргөрөгийн 50'02, зүүн уртрагийн 91,59 цэгээр нисэх буудалд хамгийн их ойртож ирдэг нь 4,5 км байна

## **Хөрс, хөрсөн бүрхэвчинд үзүүлэх сөрөг нөлөө;**

Монгол орны хөрс газарзүйн мужлалаар хөрсний өндрийн бүсшилийн Монгол-Алтайн мужийн хархираа Түргэний тойрот хамаарах ба байгалийн бус бүслүүр газрын гадаргаас хамааран нисэх буудлын бус нутагт уулын хүрэн хөрс, уулс хоорондын хөндий болон талархаг газрын хээрийн хөрс, хужирлаг хөрс, гуу жалга сайрын хөрс, Аллювын хөрснүүд тархсанаас уулс хоорондын хөндий болон талархаг газрын хээрийн хөрсөн дээр нисэх буудал байрлаж байна.

Тус хөрсний ялзмагт А давхарга 0-6см-т тархах ба цайвар хүрэн өнгөтэй бөөмөрхөг бүтэцтэй, нягтавтар, хуурайвтар, ургамалын нарийн үндэс бага зэрэг, чулуурхаг, шилжилт өнгөөр бүдэг шинжтэй байна.

Хөрсөнд хийсэн лабораторийн шинжилгээний дүнгээр нисэх буудал, түүний орчинд хүнд металл бага зэрэг илэрсэн нь Монгол улсын стандарттаас даваагүй байна. Нисэх буудлын барилга байгууламжуудын ашиглалтаас нэгэнт үүссэн нөлөө одоогийн байдлаар тогтворжсон ба түүнд дасан зохицох байдалтай болсон.

Хүснэгт;1

## **Хөрс, хөрсөн бүрхэвчинд үзүүлэх нөлөөллийн эрчмийн үнэлгээ.**

	Үзүүлэх нөлөө	Үр дагаврын чанарын үнэлгээ				
		Нөлөөгүй	Бага	Дунд	Их	Аюултай
1	Бүтээн байгуулалтаар хөрс хуулна			x		
2	Шимт хөрсийг түр хугацаанд хадгалах шаардлага үүснэ		x			
3	Нисэх буудлын үйл ажилгааны хатуу, шингэн хог хаягдал гарч хөрс бохирдуулна		x			
4	Халаалтын хэрэгцээний уурын зуух нь нүүрс хэрэглэх, үнс гаргана.		x			
5	Энгийн нүхэн жорлонг устгаж үгүй болгосон	x				

## **Ургамал, Ургамалан нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөө:**

Нисэх хамгаалалтын зурvas доторхи ургамалжилтай хэсэг нь байгалийн ургамалан нөмрөгөөс илүү ургацлаг байх тул тэнд мэрэгчид олшрон байрших нөхцөл болно. Тиймээс нисэх буудлын аюулгүйн зурvas дахь олон наст өвсөн бүрхэцийг тодорхой хугацаагаар хадаж намсгаж, биомассыг нь бууруулах арга хэмжээ авч ажиллаж байна. Бус нутгийн ургамалжилтийн байдал, ургамалжилтанд нөлөөлөх байгалийн хүчин зүйл, нисэх буудлын үйл ажиллагаа зэргийн уялдаа холбоо, ургамалан нөмрөгт төслөөс үзүүлэх нөлөө зэргийг авч үзээд нөлөөллийг эрчмийн аргаар үнэлвэл сөрөг нөлөөллийн эрчим маш багаас бага зэргийн түвшинд үйлчилж байна.

Хүснэгт 2;

**Ургамал, Ургамалан нэмрөгт үзүүлэх нөлөөллийн эрчмийн үнэлгээ.**

Нөлөөллүүд		Нөлөөллийн үр дагаварын үнэлгээ			
		Маш бага	Бага	Дунд	ИХ
					Онц аюултай
Нисэх буудлын өргөтгөлийн үйл ажиллагаагаар хөрс хуулгагдахад хэсэгчилсэн байдлаар ургамалан нэмрөг устана.		X			
Нисэх буудлын үйл ажиллагаагаар хамгаалалтын зурvas дахь ургамалжилт нь бэлчээрийн ачаалал авахгүй болсон байна.	X				
Нисэх буудлын хамгаалалтын зурvas доторхи ургамалжилтанд үндэсний үржил идэвхитэй болсоноор мэрэгчидийг ихээр цуглуулна.		X			
Нисэх буудлын үйл ажиллагаанд ашиглаж байгаа хогийн цэг бага зэргийн бохирдол үүснэ.		X			
Нисэх буудлын үйл ажиллагаанаас шалтгаалж бус нутгийн байдал өөрчлөгдөхгүй.	X				
Ховор болон үнэт статустай ургамалын тархалтанд нисэх буудлын үйл ажиллагаа нөлөөлөхгүй.	X				
Нисэх бууплын ногоон байгууламжыг шинээр нэмж байгуулна		X			
Дүгнэлт			Ургамал, ургамалан нэмрөгт үзүүлэх сөрөг нөлөөллийг нийт 7 үзүүлэлтээр үнэлхэд 42,9 хувь нь маш бага, 57.1 хувь нь бага зэргийн түвшинд байна. Ургамал, ургамалан нэмрөгт үзүүлэх сөрөг нөлөө одоогийн байдлаар дунд зэргийн төвшинд хүрэхгүй эрчимтэй байна.		

**Төслөөс амьтны аймагт үзүүлэх сөрөг нөлөө:**

Нисэх буудлын үйл ажиллагаатай холбоотойгоор нисэх буудал орчимд тохиолдох амьтны аймагт дараах байдлаар бам болон шууд нөлөөг үзүүлнэ. Үүнд;

Аэродромын орчинд агаарын хөлгийн өндөр алдах, газардах болон хөөрөх, өндөр авах үед хөхтөн амьтан болон шувууд онгоцтой мөргөлдөх, эндэх, агаарын хөлөгт аюул учруулах.

Нисэх буудлын гаднах болон доторх дэд бүтэц буюу өндөр хүчдэлийн шугамд том биетэй нүүдлийн шувууд болон махчин шувууд хүчдэлд цохиулж эндэх эрсдэлтэй.

## 2. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөнүүд	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмж их нэгж	Нэгжийн зардал \төгрөг\	Тоо хэм жээ	Нийт зардал мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа давтамж	Биелэлт
1	Нисэх буудлын барилгын ажлын үед шимт хөрс хуулах	Хуулсан шимт хөрсийг хар салхинаас хамгаалж хамгаалалтын тороор хучих.	Барилгын ажлын үед	Боод ол	120,000	5	600,000	1 удаа	2023 онд нисэх буудлын орчимд барилгын ажил хийгдээгүй.
2	Хөрс болон газрын доорхи ус бохирдох	Бохир усны цооног, хогийн цэгийн орчимд ариутгал, халдвартгүйжүүлэлт хийлгэх.	Нисэх буудлын талбай.	Удаа	120,000	2	240,000	Жилд 2-оос доошгүй удаа	Нисэх буудлын бохирлын 11 цооногийг 6 сард галын авто машинаар даралттай усаар шүршиж хуримтлагдсан бөглөөс зэргийг гаргаж ариусахуй ххк гаар хогийн цэгийн орчим 11 цооногийг ариутгал хийлгэж ажилласан.
3	Шатахууны агуулахаас үүсэх агаарын бохирдол	Техник тоног төхөөрөмжийн бүрэн бүтэн байдал	Шатахууны агуулахын орчим		Удирдлаг, Менежментийн зохион байгуулалт, ажлын чанар, дотоод хяналтын тогтолцоогоор хэрэгжүүлэх.		Байнга		Шатахуунаас үүдэлтэй сөрөг нөлөөллийг бууруулахын тулд нисэх буудал шатахууны савны доод суурийг бетон цутгаж хөрс

									бохирдооос сэргийлж сөрөг нөлөөллийг бууруулан ажилласан одоогийн байдлаар шатахууны агуулахын шугам хоолой, гидрант, насос, сав зэрэг тоног төхөөрөмжийн ажиллагаа хэвийн бөгөөд нефтийн бүтээгдэхүүн асгарсан, дуссан зүйл ажиглагдаагүй.
4	Гадаргын урсацад тохиргоо хийнэ.	Үерийн суваг доторхи хуримтлагдсан хагшаасыг цэвэрлэх	Нисэх буудал орчимд	Удаа	50,000	2	100,000	Тухайн үед нь	Нисэх буудлын үерийн далангийн суваг доторхи хуримтлагдсан хог, ургамалын хагшаасыг 2 удаа цэвэрлэж ажилласан.

### 3. Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөөний биелэлт

№	Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлт ийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмж ээ	Нэгж зардал төгрөг	Нийт зардал мян,төг	Хэрэгжүү лэх хугацаа ба давтамж	Биелэлт
1	Зүлэгжүүлэх	Олон настын үр авах	Нисэх буудлын цамхагийн хэсэг	КГ	5	22,000	110,0	2023 онд	Нисэх буудлын гадна тохижуулах ажлын хүрээнд 48м кв талбайд зүлэгжүүлэх ажлыг хийж ажилласан.
	Нийтийн талбайн зарим хэсгийг ногоон бүс болгох	Жигдний суулгац авах	2023	Ширхэг	200	5000	100,0000		Төсвийн хэмнэлттэй холбоотойгоор жигдний суулгац тарих ажил хойшилсон бөгөөд 2024 оны төлөвлөгөөнд дахин тусгана.
							110,000 төг		

## **Ногоон бүс байгуулахад баримтлах зарчим.**

**Аэродромын хамгаалалтын бүс.** Нисэх буудлын амьдрах орчны хяналт үнэлгээнд ан амьтадаас үзүүлэх эрсдэлийг бууруулхын тулд хамгаалалтын зурvas дахь ногоон нэмрэгийн бүтэц, төлөвийг аажимдаа бүтээмж багатай, тачир нам ургамалаар сольж үзэгдэх орчныг сайжруулна. Нисэх буудлын орчны ногоон бүсийг өргөтгөх, хөгжүүлэхэд БОННҮ-д дурдсан зөвлөмжүүдийг дагаж мөрдөхөөс гадна дараах зарчмыг баримтална. Үүнд:

- Аэродромын орчинд зөвхөн зүлэгжүүлэлт хийх ба аэродромын ажиллагаанд саад нэмэгдүүлэхгүй тулд мод, сөөг байршуулахгүй.
- Аэровокзал орчмын ногоон бүсэд хамгийн өндөр нь 1.5м өндөртэй сөөг ургамал байршуулна.
- Нисэх буудлын орчны ургамалжилтанд үндэслэг иш, үндсээр үржигч ургамалыг сонгохгүй.

## **Нисэх барилга байгууламж бүхий нийтийн эзэмшилийн бүсэд.**

Ногоон бүсэд сөөг байршуулахдаа барилга байгууламж, инженерийн шугам сүлжээ төлөвлөхөд ногоон байгууламжийн ойртох зай хэмжээг баримтална.

**Хүснэгт: Барилга байгууламж, инженерийн шугам сүлжээг төлөвлөхөд ногоон байгууламжийн ойртох зай хэмжээ.**

№	Барилга байгууламж, зам, инженерийн шугам сүлжээ.	Барилга байгууламж, зам, инженерийн шугам сүлжээний тэнхлэг.	
		Шилмүүст болон навчит модны гувар, ишний тэнхлэг хүртэл / метр/	Бут сөөг, сөөгөнцөрийн гол хүртэл /метр/
1	Барилга байгууламжийн гадна хананаас	5.0	2.0
2	Явган зам, цэцэрлэгжсэн замын хашлагын захаас	1.0	0.7
3	Авто машин, тролейбусны замын зах, хашлаганаас	1.5	0.6
4	Гудамжны зорчих хэсгийн ирмэг, замын хажуугийн хашлагаас	2.0	1.0
5	Түшиг ханийн дотоод ирмэг буюу улнаас	1.5	0.6
6	Цамхаг ба тавцангийн ханын голоос	2.0	1.0
7	2 метр ба түүнээс өндөр хашааны хананаас	4.0	1.0
8	Газар дээрхи болон доорх шугам сүлжээнээс Үүнд: 1. Дулаан дамжуулах яндан хоолойноос 2. Цэвэр бохир усны яндан хоолойноос 3. Цахилгаан дамжуулах кабел утаснаас 4. Гэрлийн шонгоос	3.0 3.0 2.5 5.0	3.0 3.0 2.0 2.0
9	Таримал мод ургамалын: 1. Ургамалын ххорондын зай 2. Эгнээ хоорондын зай 3. Сөөлжлөн суулгасан эгнээ хоорондын зай	3.0-4.0 2.5-4.0 2.5-4.0	0.7-1.5 1.0-1.5 1.0-1.5

### **Аэровокзал болон нийтийн эзэмшлийн талбай.**

Ногоон байгууламжид байршуулах сөөгний төрөлд хайлаас, хус, нарс зэрэг мод, шар хуайс, голт бор, жигд зэрэг сөөгийг сонгоно. Ногоон байгууламжид байршуулах сөөг хоорондийн зай 0.8м ээс багагүй байна.



### **Зураг:**

Нисэх буудалд байршуулах сөөгнүүд, зүүн гар талаас голт бор, нарс, хайлаас зэрэг моднууд.

## **Осол, эрсдэлийн менежмент.**

### **Эрх зүйн үндэслэл:**

Үндэсний хөтөлбөр батлах тухай асуудлын хүрээнд Монгол улсын засгийн газрын 2007 оны 7-р сарын 10-ны өдрийн 175 тоот тогтоолоор баталсан иргэний нисэхийн аюулгүй байдлын үндэсний хөтөлбөрийн 6-р бүлэгт нисэх буудлын аюулгүй байдлын талаархи зүйлийг тусгасан байдаг нь үйл ажиллагааг хэвийн явуулахтай холбоотой үйлчлүүлэгчдийг халдлагаас хамгаалхад голчлон чиглэсэн байдаг.

Иргэний нисэхийн тухай хуулийг 1999 оны 1-р сарын 21 ний өдөр матлан мөрдөж эхэлсэн бөгөөд Иргэний нисэхийн үйл ажиллагааг Монгол улсын олон улсын гэрээ, хэлэлцээрт нийцүүлэн зохицуулахдаа Иргэний нисэхийн багц дүрмийг баримтлахаар тусгаж өгсөн бий.

Зам тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 6-р сарын 12-ны өдрийн 187 тоот тушаалаар Иргэний нисэхийн багц дүрмийг баталсан байдаг. Багц дүрэм дотороос Иргэний нисэхийн үйл ажиллагааг зохицуулдаг Иргэний нисэхийн дүрэм Аэродромын үйл ажиллагаа, гэрчилгээжүүлэлт буюу ИНД-139 нь байгуулгын гэрчилгээжүүлэлтийн суурь стандарт, үйл ажилгааны болон аюулгүй байдлын аудитын тусгай шаардлагыг агуулсан байдаг нь аэродромын аюулгүй ажилгааг хангахад шаардлагатай тоноглол, аэродромын аюулгүй ажилгааны хамгаалалтын талаар тусгаж өгсөн бий.

### **Эрсдэлийн үнэлгээний хамрах хүрээ**

Эрсдэлийн үнэлгээ бол удирдлагын арга юм. Эрсдэлийн удирдлагын дэмжих хэрэгслийн хувьд эрсдлийн үнэлгээ нь ажлын байраа илүү аюулгүй, эрүүл болгох, мөн бизнесийн үр ашиг, өрсөлдөх чадварыг сайжруулхад нь туслах зорилготой. Эрсдэлийн үнэлгээг төсөл хэрэгжүүлэгч өөрийгөө үнэлэх зорилгоор өөрийн үйл ажиллагаандaa авч үздэг байх шаардлагатай. Бөгөөд Боннү-н хүрээнд хийж буй эрдэлийн үнэлгээ нь төсөл хэрэгжүүлэгчид зайлшгүй авч үзэх асуудлуудыг тодорхойлж өгч байгаа хэрэг юм. Тиймээс эрсдэлийн үнэлгээнд :

- Байгаль цаг уур бус нутгийн физик газар зүйн онцлогоос шалтгаалан үүсэж болох гамшигт эрсдэл
- Үйлдвэрлэйн нөхцөл буюу нисэх буудлын үйл ажиллагааны аюулгүй ажиллагааны үр дагавараас бий болох үйлдвэрлэлийн осол эрсдэл
- Шувуунаас үүсэх эрсдэлийг авч үзнэ .

Болзошгүй эрсдэлийн шалгуурууд

Сүүлийн жилүүдэд уур амьсгалын өөрчлөлт, хотжилт, хнү амын төвлөрлийн улмаас аюулт үзэгдэл, оёлын тоо нэмэгдэж түүнээс үүдсэн хор уршиг, хохирлын хэмжээ эрс өсч гамшгийн шинжтэй болох болсон. Болзошгүй эрсдэлийн нөхцөл байдал нь нэг талаас байгалийн гамшигт үзэгдлээр, нөгөө талаас хүний үйл ажиллагаатай холбоотой бөгөөд эдгээрийн хайлцан хамаарал нь урт хугацаандаа улам ихсэж байна.

Болзошгүй эрсдэл үүсэх нөхцөл нь аль ч тохиолдолд урт хугацааны дарамтыг тэсвэрлэх боломжгүй болсноор гэнэт сэдрэх байдлаар нөхцөлдөх нь гамшгийн шалтгаан болдог учраас эрсдэлийн нөхцөл байдлыг өль болох урьдчилан үнэлж, бэлэн байх, урьдчилан сэргийлэх, зайлшгүй тохиолдолд бууруулаах, гамшгийн дараа хор, уршигийг арилгахь сэргээн босгох зэрэг дэс дараатай үйл ажиллагааг шаардах болсон.

Аливаа эрсдэлийн үр дагавар нь учирсан хор уршиг байх бөгөөд энэ нь хүн ам болон эд хөрөнгөнд хор хохирол учруулах байдлаар илэрнэ. Тиймээс эрсдэлийн үнэлгээ бол өөртөө туслах хэрэгсэл юм. Эрсдэлийн уршигийг магадлалын шалгуураар үнэлэх бөгөөд БОННҮ-Д шалгуурын 5 зэрэглэлийг түгээмэл ашигладаг.

#### **Хүснэгт. Болзошгүй эрсдэлийн магадлалын шалгуур үзүүлэлт.**

Зэрэглэл	Магадлал	Эзлэх хувь	Эрсдэлийн тодорхойлолт
1	Тохиолдол бараг байхгүй	5 хувь	Онцгой нөхцөлд л эрсдэл тохиолдоно
2	Болох магадлалтай	5-20 хувь	Эрсдэл үүсэх нөхцөл үгүй ч заримдаа эрсдэлтэй байж болно.
3	Болзошгүй эрсдэлийн нөхцөлтэй	20-50 хувь	Хянахгүй бол эрсдэл үүсэх нөхцөл бүрэлдэх боломжтой
4	Эрсдэх магадлалтай	50-70 хувь	Эрсдэл үүсэх нөхцөл байх тул байнгын хяналт мэдээлэлтэй байх
5	Эрсдэл тохиолдох нөхцөлтэй	70 хувийас их	Эрсдэлс үүсэх өндөр эрсдэлтэй тул байнгын бэлэн байдалд байх

Эрсдэл тодорхойлсоноос үүссэн нь нэг талаас хүн амд, нөгөө талаас эд хөрөнгөнд хор уршиг учруулах учраас уршигийн БОННҮ-нд мөн 5 шалгуураар үнэлдэг.

#### **Шувуудаас агаарын хөлөгт аюул учруулах эрсдэлийг тодорхойлох**

Бид шувууд агаарын хөлөгт аюул учруулах эрсдэлийг тодорхойлохдоо C.Paton(2009) аргыг ашиглав. Энэ нь шувуудын зүйл тус бүрийг мөргөлтөөс үүсэх аюул (Шувууны биеийн хэсжээ болон сүрэглэн нисэх байдал) ба мөргөлдөх боломжид (Элбэгшил, тохиолдох магадал) тулгуурлан эрэмблэх арга юм.

### Шувууны аюулыг үнэлэх матриц, магадлал үр дагавар /хүснэгт /

Аюул	Магадлал			
	Маш их	Их	Дунд	
<b>Хэт их</b>	Хэт их	Хэт их	Маш их	Их
<b>Маш их</b>	Маш их	Их	Их	Дунд
<b>Их</b>	Их	Их	Дунд	Дунд
<b>Дунд</b>	Дунд	Дунд	Бага	Бага
	Бага	Бага	Ач холбогдолгүй	Ач холбогдолгүй
<b>Маш бага</b>	Ач холбогдолгүй	Ач холбогдолгүй	Ач холбогдолгүй	Ач холбогдолгүй

#### Мөргөлтөөс үүсэх аюулыг тодорхойлох:

Үүнийг тодорхойлоходоо шувууны биеийн хэмжээ болон кан төрхийн мэдээллийг ашиглав. Шувууны мөргөлтөөр агаарын хөлөгт учрах хохирол нь шувууны биеийн жин (нөлөөлийн хүч), сүргийн хэмжээ (нэг удаагийн тохиолдлоор мөргөлдөж болзошгүй шувуудын тоо) зэргээс хамаардаг.

Үүнд:

- Шувуудын биеийн жинг 6 зэрэглэлээр
- Сүрэглэх зан төрхийг 3 зэрэглэлээр
- Нисэлтийн хэв маягийг 2 зэрэглэлээр ангилна

Дээрх 3 үзүүлэлтийн нэгдсэн дүн нь “Аюул”-ын зэрэглэл болно .

#### Хүснэгт Шувууны биеийн жинд харгалзах оноо

Биеийн жин	Жишээ	Биеийн жингийн оноо
20г	Хараацай, дууч шувуу гэх мэт	1
21-50г	Бор шувуу, божирго гэх мэт	2
51-200г	Тодол цэнхэр хараацай, хайргуурна шонхор гэх мэт	4
201-1000г	Турлиах, үлэг харцага, монгол ногтруу, гэх мэт	8
1-5 кг	Шилийн сар, хон хэрээ, тураг гогой, хондон ангир, гэх мэт	16
5кг	Гангар хун, хонин тоодог, нөмрөг тас, өвөгт ногтруу гэх мэт	32

#### Байгалийн эрсдэлт үзэгдлүүд

##### Бүс нутгийн физик газарзүйн нөхцөл

Газрын гадарга, өндөршил . “Дэглий цагаан” нисэх буудал нь Увс аймгийн тэргэн сумын 1-р багийн нутаг дэвсгэрт сумын төвийн зүүн хойд зүгт 18 км, Улаангом хотоос баруун зүгт 14 км зайд, Увс аймгийн Түргэн, Улаангом сумдын нутгийн дамнанам хойд өргөрөгийн 50,04"00", зүүн уртрагийн 91,56'11" далайн мандлаас 935 м-ийн өндөрт байрлах бөгөөд гадаргуугийн налуу 0,1% байна.

Газрын бартаа өндөршилийн ялгаа нь нисэх буудлын үйл ажиллагаанд нислэгийн хөөрөх буух үеийн саадыг үүсгэдэг.

Цэвдэг: Нисэх буудлын талбай нь Монгол орны цэвдэг м хөрсний чулуулагийн мужлалаар алаг цоог , ховор алаг цоог төрхсөн цэвдэг бүслүүр хамаарах бөгөөд цэвдэг хөрсний үзүүлэлт нь 20 м-н гүн дэх температур -1 хэмээс -5 хэмийн цедсид байх ба улирын цэвдэг чулуулаг 0 хэмээс -3 хэмд, улирлын хөлдөлтийн гүн 2,5 м-ээс 5,0 м хүрдэг .

**Чичирхийлэл :** :Дэглий цагаан нисэх буудал нь шинэхэн тектоникийн мужлалаар Их нууруудын хотгор –нууруудын хөндийн бусэд багтах бөгөөд энэ нь дэлхийн царцасын тасралтат ба уян харимхай хэв гажилтаар харьцангуй хүчтэй хотолттой бус юм . Тус бүс газар чичирхийллийн мужийн BSK-64 шатлалын баллаар 9а, түүнээс дээш шатлалд хамаарна. Газар чичирхийллийн идэвх 0,05-0,1 байх ба доргилтын эрчим нь MSK шатлалын баллаар 6-7 газар хөдлөлтийн голомт үүсч болох бүсийн талбай Рихтерийн шатлалаар 7,1-7,5 баллын түвшинд байна .

Увс аймгийн Тариалан сумын төвөөс хойд зүгт 12 км –н зайд Хөхөө багийн нутагт “Хөхөөн уул гэдэг газарт ” /У-91,86 Θ-49,88/ 2015 онд 3,7 магнитудын хүчтэй газар хөдлөлт тэмдэглэгдсэн нь Улаангом хот болон тариалан сумын төвд мэдрэгдсэн байдаг.

**Үер:** “Дэглий цагаан ” нисэх буудлын ашиглалтын талбай нь Цалгар гол руу урсацтай нэргүй 2,3 жижиг, хуурай сайрын ус хураах талбайг дамнан байршиасанаас гадна “Дэглий цагаан ” нисэх буудлын бүс нутагт гадаргын усны хамгиын их урсац нь хур борооны улирал буюу 6-8 дугаар сард, зарим жилүүдэд хаврын шар усны үерийн үед ажиглагддаг байна .

#### **Үйлдвэрлэлийн осол эрсдэл, түүний нөхцөлүүд**

#### **Үйлвэрлэлийн осол, эрсдэлтэй нөхцөлүүд**

ИНД-139 дүрэмд аюулгүй ажиллагаатай нисэх бууадал болохыг тодорхойлон гэрчилгээжүүлснээр тухайн нисэх буудал нийтэд аюулгүй үйлчилгээ үзүүлэх эрх бүхий болдог байна .

- ❖ Аэродромын төлөвлөлт, хязгаарлалт шийдэл –Дэглий цагаан нисэх буудлын хувьд олон улсын буудлын 4С ангилалын шаардлагад нийцнэ.

- ❖ Гал түймрийн эрсдэлийн Дэглий цагаан нисэх буудлын хувьд дараах нөхцөлүүд бий .Үүнд:
  - ✓ Онгоц ослын буулт хийх үеийн эрсдэл
  - ✓ Шатахууны ил агуулах
  - ✓ Уурын зуухны нүүрсний ил хадгалалт
  - ✓ Барилга байгууламжийн цахилгааны угсралт
  - ✓ Цахилгаан хангамжийн найдвартай байдал
- ❖ Нийтийн хамгааллын талаар нисэх буудлын барилга байгууламжууд нь нисэх буудлын зориулалттай.
- ❖ Мал, амьтан шудуудаас үүсэх аюул, эрсдэл Дэглий цагаан нисэх буудлын хувьд бий .Үүнд:
  - Аюулгүй бусийн доторх хашаалсан талбайн ургамалжилтаас шалтгаалан бэлчээрийн жижиг мэрэгчид газар доорх хөдийлж, үлий үүсгэснээс газар цөмрөх
  - Жижиг мэрэгчдийн олширолыг дагаад тэдгээрээ хоолплодог жижиг араатан, махчин шувууд элбэгшиж, ялангуяа шувууд нислэгийг хөөрөгх болон буулгах үед онгоцтой мөргөлдөх
- ❖ Мэдээлэл, түүнийг зарлан мэдээлэх тухайд:
  - Дэглий цагаан нисэх буудлын аэродромын хязгаарлах үзүүлэлт саадуудыг зарлан мэдээлсэн.
  - Нислэгт эрсдэлтэй байгалийн үзэгдлээс сэргийлэх мэдээлийг нисэхийн цаг уурын төвөөс зарлан мэдээлдэг .
